

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



УЛААНБААТАР ХОТ  
АВИР ТРЕЙД ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Э.ЭНХМЯГМАР



ТУУЗАН ДАМЖЛАГЫН ТУУЗ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 21/2022

20<sup>22</sup> оны 7-р сарын 21

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Авир трейд ХХК-ийг төлөөлж захирал Э.Энхмягмар /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дах заалт, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2022 оны А/104 дүгээр тушаал, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

### Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь “Туузан дамжлагын тууз” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

### Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 45 /дөчин тав/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

### Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1. Энэ гэрээний нийт үнэ 39,900,000 /гучин есөн сая есөн зуун мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2. Гэрээний үнийн дүнгийн 50/тавь/-н хувь болох 19,950,000 /арван есөн сая есөн зуун тавин мянга/-н төгрөгийг гэрээ баталгаажсанаас хойш ажлын 5/тавь/ хоногийн дотор нийлүүлэгчийн Голомт банкны 1415105671 тоот дансанд шилжүүлнэ. Гэрээт ажлын үлдэгдэл төлбөрийн 50/тавь/-н хувь болох 19,950,000 / арван есөн сая есөн зуун тавин мянга/-н төгрөгийг барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан баримт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш 30 /гуч/ хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Голомт банкны 1415105671 тоот дансанд шилжүүлнэ.

### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

- 4.2.Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3.Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4.Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Түлш дамжуулах цехийн дарга Д.Түвшинзаяа хариуцан ажиллана. Утас-99026048.
- 4.5.Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Авир трейд ХХК-ийн захирал Э.Энхмягмар хариуцан ажиллана. Утас-99660871.

#### **Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол**

- 5.1.Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2.Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэх, хэмхэрэхээс хамгаалсан сав, баглаа боодолтой, шинэ байна.
- 5.3.Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4.Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

#### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1.Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2.Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

#### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1.Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2.Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

#### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1.Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө.Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.
- 8.2.Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

## Ес. Бусад нөхцөл

- 9.1.Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 10 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2.Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3.Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4.Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5.Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6.Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7.Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  
Э.МӨНХЖАРГАЛ  
Гарын үсэг:



СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ  
Ө.УДВАЛ  
Гарын үсэг:



ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г.ЭРДЭНЭБИЛЭГ  
Гарын үсэг:

ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХИЙН ДАРГА  
Д.ТҮВШИНЗАЯА  
Гарын үсэг:



ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г.САРУУЛ  
Гарын үсэг:



ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН  
С.БОЛД  
Гарын үсэг:



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АВИР-ТРЕЙД ХХК-ИЙН  
УЛААНБААТАР ХОТ

ЗАХИРАЛ  
Э.ЭНХМЯГМАР  
Гарын үсэг:



Хаяг: БГД 24-р хороо 15-150 тоот  
Утас: 99660871  
РД: 6023207.

Тоот гэрээний хавсралт

Туузан дамжлагын тууз материалын жагсаалт

№	Бараа материалын нэр	Барааны гарал үүслийн улс	Марк	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	НӨАТ-тэй Бүгд үнэ
1	Туузан дамжлагын тууз	БНХАУ	Өргөн-800мм, зузаан-10мм-с дээш, үе-6-с дээш, ажлын талын зузаан-5мм-с дээш	м	200	199,500	39900000
3	Нийт						39900000

Амгалан дулааны станц ТӨХК-ийн  
Түлш дамжуулах цехийн дарга

Авир трейд ХХК-ийн Захирал



Д.Түвшинзаяа

Э.Энхмягмар

## Барааны үнийн задаргаа

№	2	3	4	5	6	7	8	9	10	11
	Барааны нэр	Гарал үүслийн улс	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4хб)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Бараа нийлүүлэхэд ноглох тагвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)	Монгол улсын үүсэлтэй бараа мөн эсэх
1	Дамжлагын тууз	БНХАУ	200	м	138,245	27,649,000	5,723,750	6,527,250	39,900,000	Үгүй
<b>Тендерийн нийт үнэ</b>										39,900,000



Захирал ..... Э.Э.Хмятмар